

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК- УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙДВЭРИЙН ЯАМ

**ТА 9752 МОН - МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ
ТӨСӨЛ**

2021 ОНЫ АХИЦ ДЭВШЛИЙН ТАЙЛАН

2022 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр

Contents

Товч танилцуулга	2
БҮТЭЭГДЭХҮҮН I. ОУИТБС-ын стандартыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах 3	
ОУИТБС-ын тайлангийн маягт, цахим сан шинэчлэх болон нийгмийн сүлжээг идэвхжүүлэх	3
ОУИТБС-ын 2020 оны тайлагнал	4
ОУИТБС-ын 2020 оны нэгтгэл тайлан боловсруулах байгууллагыг сонгох үйл ажиллагаа.....	4
БҮТЭЭГДЭХҮҮН II. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх.....	6
ЭБСИТБ-ын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах талаар хуулийн зөвлөхүүд ажилласан нь.....	6
БҮТЭЭГДЭХҮҮН III. Мэдээлэл түгээх ажлыг сайжруулах боломжийг судлах, олборлох салбарын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх	6
Орон нутгийн дэд зөвлөлүүдтэй хэрэгжүүлж буй харилцаа холбоо	6
Сургалтын үйл ажиллагаа.	8
Харилцааны мэргэжилтэн ажиллуулж байгаа нь.....	11
ОУИТБС-ын Ажлын албаны санхүү, худалдан авалтын тайлан.....	11

Товч танилцуулга

Монголын ОУИТБС-ын Ажлын албыг 2019 оны эхээр Ерөнхий Сайдын ажлын албанаас Уул уурхай хүнд үйлдвэрийн яаманд шилжүүлсэн билээ. УУХҮЯ- аас холбогдох арга хэмжээг авч, Ажлын албаны улсын төсвийн санхүүжилтыг шийдвэрлэсэн байна. 2019 оны 7 дугаар сард Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Азийн хөгжлийн банк Монголын ОУИТБС- ын үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Олборлох салбарын засаглалыг сайжруулах ТА 9752 MON” төслийн гэрээг байгуулж, санхүүжилтыг бүрэн шийдвэрлэсэн байна.

Эдгээр туслалцааны үр дүнд Монголын ОУИТБС-ын үйл ажиллагаа жигдэрч, 2019 оны эцсээр 2018 оны нэгтгэл буюу 13 дугаар тайлан, 2020 оны эцсээр 2019 оны нэгтгэл буюу 14 дүгээр тайлан, 2021 оны эцсээр 2020 оны нэгтгэл буюу 15 дугаар тайланг тус тус боловсруулан, ОУИТБС-ын стандартын дагуу хэвлэн нийтлүүлсэн байна. Тайлангуудыг монгол, англи хэл дээр бэлтгэж, ОУИТБС-ын Ажлын албаны цахим хуудас www.eitimongolia.mn <http://www.eitimongolia.mn/p/33> гэсэн хаягаар байршуулсан байна.

Нөгөө талаас, Кокид-19 өвчний цар тахлын бэрхшээл, хөл хориотой байсан хэдий ч Монголын ОУИТБС-ын Ажлын алба, төслийн баг 2020-2021 оны Ажлын төлөвлөвөгөөгөө амжилттай хэрэгжүүлсэн байна.

ОУИТБС-ын Ажлын албанаас төлөвлөн 2021 онд зарим талаар амжилттай хэрэгжүүлсэн үйл ажиллагааг танилцуулбал, Үүнд:

- Системтэйгээр ил тод болгох суурийг 2021 онд бий болгож, ирэх жилүүдэд шинэчилнэ гэсэн үйл ажиллагааны хувьд – Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд “Системтэйгээр ил болгох” тухай хуулийн зохицуулалтыг боловсруулан оруулсан бөгөөд Улсын Их хурлаас 2021 оны намрын чуулганд хэлэлцэх хууль тогтоомжийн жагсаалтад уг төслийг оруулсан байна.
- ОУИТБС-ын дэд зөвлөлүүдийг үйл ажиллагааг 2021 онд сэргээж, чадавхийг нэмэгдүүлнэ гэсэн үйл ажиллагааны хувьд – Дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, цахимаар 2 сар тутам уулзаж, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээллээ солилцож, уялдуулж байна.
- Олон улсын санхүүгийн корпорац, Нээлттэй нийгэм форум, мэргэжлийн холбоод болон бусад байгууллагуудтай хамтран явуулах үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, үр өгөөжтэй болгоно гэсэн зорилтын хувьд- Дурдсан байгууллагуудтай хамтран явуулах ажиллагаагаа эрчимжүүлж, Дэд зөвлөлийг идэвхжүүлэх, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах, батлуулах, сургалт сурталчилгааны бүтээгдэхүүн хэвлэх ажлыг бэлтгэх чиглэлээр хамтран ажилласан байна.
- Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын системийг хэрэглэгчдэд ээлттэй, хэрэглэхэд амар хялбар байхаар хөгжүүлэх гэсэн үйл ажиллагааны хувьд – Энэхүү тайлагналын цахим системийг шинэчилэн хөгжүүлж, Компани, Засгийн газрын байгууллагууд, Нэгтгэлийн тайланг хэрэглэгч нарт харуулдаг болгосон байна.

Азийн Хөгжлийн банкны Техник туслалцааны төслийн дагуу бүтээгдэхүүн бүрээр хийсэн үйл ажиллагааны тоймыг ерөнхийд нь танилцуулья. Үүнд:

БҮТЭЭГДЭХҮҮН I. ОУИТБС-ын стандартыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах

ОУИТБС-ын тайлангийн маягт, цахим сан шинэчлэх болон нийгмийн сүлжээг идэвхжүүлэх

ОУИТБС-ын тайлагналын маягтыг шинэчлэх ажил үргэлжилж, өмнө нь ороогүй байсан геологийн ажлын зардал, хүн амын орлогын албан татварын суутгал, хөрөнгийн зардал, Засгийн газрын байгууллагуудад төлсөн тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс, өөрөөр хэлбэл, маягтны сүүлчийн хэсгийг оруулсан байна. Энэ ажлыг системийг анхнаас нь боловсруулсан Монголын Интерактив хэмээх мэдээллийн технологийн компанийн туслалцаа дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн байна.

Компаниудын 2020 оны тайланг харуулах явдал шийдэгдэхгүй байсан нь холбогдох үнэгүй програм хангамж хэт хоцорсон технологтой байсан. Энэ байдлыг тендерээр шалгарсан Лидер Визон групп ХХК-тай гэрээ байгуулан, засварлах, шинэчлэх ажлыг явуулсан. Гэрээт ажил дууссан турших шатандаа байна.

Өмнөх мэдээллийн технологийн ажилтны туслалцаатайгаар Монголын ОУИТБС-ын цахим санг засч, сайжруулсан бөгөөд холбогдох мэдээллүүдээ оруулж тасралтгүй баяжуулж байна. Ер нь хөгжүүлэлтийн ажил хийгдээгүйн улмаас нилээд хуучирсан учир хоцрогдлыг шийдвэрлэж байна. Нөгөө талаас, програм хоорондын тохиргоо, хурдыг сайжруулсан байна. Олон улсын санхүүгийн корпорацийн мэргэжилтний туслалцаатайгаар цахим сан, нийгмийн сүлжээн дээр байршуулах инфографикуудыг боловсруулан байршуулсан байна.

ОУИТБС-ын Ажлын хэсгээс зөвшөөрсний дагуу 2021 онд Ажлын дэд хэсгийг гаргаж, ОУИТБС-ын тайлагналын маягтад оруулах нэмэлт мэдээллийг боловсруулан, УУХҮЯ-аар зөвшөөрүүлэн, Үндэсний статистикийн хороонд хүргүүлэн батлуулах ажиллагаа явагдаж байна. Энэхүү шинэ нэмэлтээр компаниудаас жилийн төлөвлөгөө (1-2 жил), экспорт, худалдан авалт, ажиллах хүчин, дундаж цалингийн мэдээллээ тайлагнах, төрийн байгууллагуудаас хүлээн авсан хандив дэмжлэгийн зарцуулалт, эдийн үр нөлөөний тооцоо судалгаа, олборлох салбарын хэтийн төлөвийн мэдээллийг тайлагнахыг тус тус үүрэг болгох юм.

Ажлын алба нь харилцааны шинэ мэргэжилтэнтэй болсон бөгөөд тэрбээр Монголын ОУИТБС-ын цахим сан, “Facebook live”, “Twitter” нийгмийн сүлжээний мэдээллийн баяжуулалтыг хариуцан, тогтмол шинэчилж байна.

УУХҮЯ-ны цахим сангийн шинэчлэл

УУХҮЯ-наас 2021 оны 4 дүгээр сарын эхээр АХБ-ны Олборлох салбарын засаглалыг сайжруулах ТА-9752 MON төслийн хүрээнд яамны цахим сайтыг шинэчлэх хүсэлт ирүүлсэн.

Энэ хүсэлтийг АХБ-аас зөвшөөрсний дагуу ОУИТБС-ын Ажлын албанаас веб сайтыг шинэчлэх ажлыг эхлэж, УУХҮЯ, холбогдох компанийн хоорондын харилцаа холбоог уялдуулж ажилласан болно. Ажлын албаны мэдээллийн технологийн зөвлөх холбогдох ажлын даалгаврыг 4 дүгээр сарын 8-нд боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны цахим санг хэрэглэгчдэд ээлтэй байх хандлагад суурилан хөгжүүлснийг УУХҮЯ-наас баталж зөвшөөрсөн байна. Сонгон шалгаруулалтад 5 компани оролцсоноос Опен Софт ХХК 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдөр шалгарч, 11-ндээ гэрээ байгуулсан байна. Гэвч УУХҮЯ-наас хэд хэдэн нэмэлт ажил санал болгосныг холбогдох гэрээт компани бичгээр зөвшөөрсний үндсэн дээр хүлээн авсан болно. Энэ асуудлыг шийдвэрлэсний дагуу тухайн ажлыг УУХҮЯ дээр 2021 оны 11 дүгээр сард хүлээн авсан байна.

Энэ үйл ажиллагааны ахицыг 100 хувь биелсэн гэж үнэлж байна.

ОУИТБС-ын 2020 оны тайлагнал

Ажлын албаны тооцоолсноор ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны гэрээлэгч 2240 компани буюу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 1160, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 1060, бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий 20 компани ОУИТБС-ын 2020 оны тайлангаа шинэ маягтаар гаргана.

Тайлан гаргах хугацааг 2021 оны 6 дугаар сарын 1-нээр эцэслэн үзэхэд 1419 компани тайлангаа ОУИТБС-ын цахим тайлангийн системд гаргасан байна. Төслийн баг компаниудтай утас, СМС, цахим шуудангаар харьцаж, тайлангаа гаргах арга зүйн зөвлөгөөг өгсөн ба зарим компанийн төлөөллийг ажлын байран дээр хүлээн авч, ОУИТБС-ын тайлангаа гаргахад бэрхшээлтэй байсан асуудлыг шийдвэрлэж, тухай бүр зөвлөлгөө өгч ажилласан байна.

Ажлын албанаас цахим тайлангийн дутууг дээр танилцуулсны дагуу нэмж сүлжээнд оруулсаны дараа компаниудын төлөөлөлд нийт 4 удаагийн вебинарыг зохион байгуулж, тайлангийн шинэ маягтын дагуу тайлангаа хэрхэн гаргах зөвлөгөөг өгсөн болно. Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоосон учир тайлагнах хугацааг сунгаж, тайлагнах боломжийг олгож, 5 дугаар сарын сүүл хүртэл тайланг хүлээж авсан болно.

Мөн ОУИТБС-ын тайлан гаргах үүрэг бүхий Засгийн газрын бүх түвшиний буюу холбогдох яамд, агентлаг, аймаг, дүүргүүдийн байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан бөгөөд тэдгээр байгууллагууд 2021 оны 7 дугаар сарын дунд хүртэл тайлангаа гаргасан байна.

Ажлын албанаас тайлангаа гаргах албан хүсэлтийг нэг яам, 8 агентлаг (татвар, ашигт малтмал, газрын тос, гааль, мэргэжлийн хяналт, төрийн өмч, хөдөлмөр нийгмийн халамж, стандар хэмжил зүй, нийгмийн даатгал, халамж), 21 аймаг, 9 дүүрэгт илгээж, Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын системээр гаргах аргачлалыг холбогдох маягт, зааварчилгаа, нэвтрэх нууц үгийн хамт хүргүүлсэн байна.

Энэхүү үйл ажиллагааны үр дүнд 7 агентлаг, Татварын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Гаалийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн халамж, үйлчилгээний газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Улсын стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын алба, Баянхонгор, Өмнөговь, Сүхбаатар, Ховд аймгаас бусад 17 аймаг, Багахангай, Баянгол, Хан-Уул дүүргээс бусад 6 дүүрэг ОУИТБС-ын 2020 оны тайлангаа цахимаар гаргасан байна.

Энэ үйл ажиллагааны ахицыг 90 хувь биелсэн гэж үнэлж байна.

ОУИТБС-ын 2020 оны нэгтгэл тайлан боловсруулах байгууллагыг сонгох үйл ажиллагаа

Батлагдсан 2021 оны ОУИТБС-ын Ажлын төлөвлөгөөний дагуу 2021 оны 1 дүгээр улиралд 2020 оны ОУИТБС-ын тайланг бэлтгэх Засгийн газрын тендерийн бэлтгэл ажлыг хангасан байна. Үүнд:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэд холбогдох хууль, журмын дагуу Үнэлгээний хороо байгуулах;
- Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавр, тендерийн баримт бичгийг боловсруулах;
- Тендерийн баримт бичгүүдийг УУХҮЯ-ны холбогдох албан тушаалтнаар батлуулах;

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалын дагуу 3 дугаар сард Үнэлгээний хороог байгуулсан бөгөөд хороонд УУХҮЯ-ны төлөөлөл 3, Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл 2, Ажлын албанаас 2 төлөөллийг тус тус оруулсан байна.

Тендерээр 3 зөвлөх үйлчилгээ бүхий багцын Ажлын даалгаврыг мөн оны 3 дугаар сард УУХҮЯ-наас батлуулсан болно. Нэгдүгээр багц нь Монгол Улсын ОУИТБС-ын 2020 оны буюу 15 дугаар тайлан боловсруулах, хоёрдугаар ажил нь Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын сүлжээг сайжруулах, гуравдугаар зөвлөх үйлчилгээ нь Монголын ОУИТБС-ын Дэд зөвлөлүүдийн чадавхийн судалгаа, Дэд зөвлөлүүдийг сайжруулахад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээг хамарч байна.

Тендерийн сонгон шалгаруулалтын ажил 3 дугаар сарын 17-ны өдөр өдөр тутмын томоохон сонин болох “Өдрийн сонин”, Засгийн газрын худалдан авах газрын www.tender.gov.mn , ОУИТБС-ын Ажлын албаны цахим сайт дээр холбогдох зар хэвлэгдсэнээр эхлэсэн байна.

Ажлын албанд 3 дугаар сарын 26-ны байдлаар 1 дүгээр тендерт 3 санал, 3 дугаар тендерт 2 санал ирүүлсэн бол 2 дугаар тендерт санал ирүүлсэн нэг ч компани байгаагүй. Хэдийгээр 1 дүгээр багцад ирсэн 3 саналтай танилцсан боловч хоёр санал нь бичиг баримтын бүрдэл хангаагүй тул богино жагсаалт үүсгэх боломжгүй байсан тул хуулийн дагуу дахин худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. 4 дүгээр сарын 30-нд дахин зарласан тендерийн дагуу 5 дугаар сарын 13 гэхэд 3 тендер тус бүрт богино жагсаалт үүсгэж, 4 оролцогчийг сонгон УУХҮЯ-аар баталгаажуулсан байна.

Тендерүүдийн техникийн саналыг 6 дугаар сарын 15-нд, санхүүгийн саналыг 6 дугаар сарын 30-нд нээсэн холбогдох үнэлгээг хийж, дүнг УУХҮЯ-нд оруулсан.

Гэвч тендерийн хугацааг сунгах шаардлагатай болсон тул УУХҮЯ-наас холбогдох хүсэлтийг СЯ-д хүргүүлснийг ёсоор болгосон байна.

Үүний үр дүнд шалгарсан Грант Торнтон аудит ХХК, Лидер Визон групп ХХК, Хүний хөгжил сургалтын төвтэй гэрээ байгуулж, УУХҮЯ-наас баталгаажуулсны дагуу гүйцэтгэгч нар 2021 оны 7 дугаар сарын эцсээр ажлаа эхлүүлсэн байна. Тендерийн үнэлгээний хороо нийт 14 удаа цахимаар хуралдаж, хурлын тэмдэглэлээ бүгдийг хийсэн байна.

Гэрээ байгуулсны дараа Ажлын алба, Ажлын хэсэгтэй хамтран Монголын ОУИТБС-ын 2020 оны буюу 15 дугаар уян хатан нэгтгэл тайлангийн эхлэлийн семинарыг Грант Торнтон аудит ХХК-ийн зөвлөх багтай зохион байгуулж, тайлангийн хамрах хүрээг эцэслэн тохиролцсон байна.

Грант Торнтон аудит ХХК-тай байгуулсан гэрээний дагуу Монгол Улсын ОУИТБС-ын 2020 оны буюу 15-р уян хатан нэгтгэл тайланг боловсруулсан бөгөөд зэс, алт, нүүрсний тусгай зөвшөөрөл эзэмшигч 60 компани энэ нэгтгэлд оролцсноос гадна ОУИТБС-ын 2019 стандартын дагуу орлогын бус мэдээллийг ил тод болгосон байна.

Лидер Визон групп ХХК-тай байгуулсан гэрээний дагуу Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын сүлжээг сайжруулж, батлагдсан шинэ маягтын дутууг оруулж, компани, төрийн байгууллагууд, нэгтгэлд орсон компаниудын тайлангуудыг нийтэд ил тод үзүүлэх болсон байна.

Хүний хөгжил сургалтын төвтэй байгуулсан гэрээний дагуу Дэд зөвлөлийн чадавхийн талаар тайлан, судалгаа бэлтгүүлж, үйл ажиллагааны төлөвлөгөө, стратегийн төсөлтэй болсон бөгөөд ОУИТБС-ын Ажлын хэсэг, алба цаашид Дэд зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулахад эдгээр дүгнэлтүүдийн арга хэмжээ авах юм.

Энэхүү үйл ажиллагааны биелэлтийг 100 хувь гэж тооцож байна.

Бүтээгдэхүүн 1- ийн хэрэгжилтийн явц: 96,6 хувь

Нэгдүгээр бүтээгдэхүүний хэрэгжилтийн гол онцлог– Монголын ОУИТБС-ын 2020 оны буюу 15 дугаар тайланг цаг хугацаанд нь багтаан боловсруулсан бөгөөд 1419 компани, 7 агентлаг, 17 аймаг,

6 дүүрэг цахимаар тайлагнасан. Тендер болон түүний хийгдсэн гэрээнүүдийн ажил амжилттай хэрэгжиж, зорилтдоо хүрсэн байна.

БҮТЭЭГДЭХҮҮН II. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх

ЭБСИТБ-ын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах талаар хуулийн зөвлөхүүд ажилласан нь

Гадаад болон дотоод хуулийн зөвлөхүүд хуулийн эцсийн хувилбарыг боловсруулж, УУХҮЯ-ны Хуулийн ажлын хэсэгт ажлаа танилцуулсан байна.

Ажлын хэсэг уг хувилбарыг хүлээн авахдаа өмнөх болох шинэ хувилбарыг нэгтгэх, түүнийг хэрэгжүүлэхэд цомхон, мэргэжлийн баг ажиллуулж, аль болох богино хугацаанд боловсруулж, улмаар УУХҮЯ-наас Засгийн газрын хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэсэн шийдвэр гарсан байна.

Ил тодын хуулийн төслийг сайжруулах зорилгоор ил тодын тухай хуультай орнуудын туршлагын судалгааг гадаад хуулийн зөвлөх боловсруулж, УУХҮЯ-ны хуулийн ажлын хэсэгт танилцуулсан байна.

УУХҮЯ-ны хуулийн ажлын дэд хэсэг 12 удаа цахимаар уулзаж, 2 хувилбарыг нэгтгэн, 6 дугаар сарын 7-нд эцсийн төслийг боловсруулан УУХҮЯ-ны дотоод хяналтад оруулсан байна. УУХҮЯ цаг хугацаандаа багтаан Засгийн газрын хуралдаанд өргөн барих, улмаар Улсын Их хурлын намрын чуулганаар хэлэлцэх хуулийн жагсаалтад оруулж батлуулсан байна.

Хуулийн төслийг анх удаа ОҮИТБС-ын Төвийн бүсийн 4 дүгээр чуулган, дараа нь Баруун, Зүүн бүсийн чуулгадад танилцуулж, саналыг авсан байна.

Одоогоор хэлэлцэгдэж байгаа Ашигт малтмалын тухай хуулийн төслийн ил тод байдлын хэсэгт ил тод байдлын тухай хуулийн хуулийг нэгтгэх тухай асуудлыг хэлэлцсэн бөгөөд одоогоор энэ талаар УУХҮЯ-наас тодорхой шийдвэр гаргаагүй байна.

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг Улсын Их хуралд танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгуулах асуудлаар УИХ-ын дарга Г.Занданшатарт бараалхахад Ажлын албанаас оролцож холбогдох танилцуулгыг хийсэн байна.

Ажлын албанаас төслийг хэлэлцүүлэх ажлыг идэвхжүүлэх, олон нийтэд ойлгуулах зорилгоор Транспаренси Интернейшнл, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Нээлттэй нийгэм форум, Олон улсын санхүүгийн корпорац зэрэг байгууллагуудтай цахимаар уулзаж, хамтарч ажиллах, ажлын төлөвлөгөө боловсруулсан байна.

Бүтээгдэхүүн 2- ын хэрэгжилтийн явц: 60 хувь

Хоёрдугаар бүтээгдэхүүний хэрэгжилтийн гол онцлог: Гадаад болон дотоод хуулийн зөвлөх хуулийн шинэ хувилбарыг боловсруулахдаа хуучин, шинэ хувилбарыг нэгтгэсэн бөгөөд ил тодын хуулийн олон улсын туршлагын судалгааг боловсруулсан байна. УУХҮЯ-наас хуулийн хэлэлцүүлэгт холбогдох төслийг бэлтгээд байна.

БҮТЭЭГДЭХҮҮН III. Мэдээлэл түгээх ажлыг сайжруулах боломжийг судлах, олборлох салбарын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Орон нутгийн дэд зөвлөлүүдтэй хэрэгжүүлж буй харилцаа холбоо

Ажлын алба аймгуудын ОУИТБС-ын бүх дэд зөвлөлүүдтэй зөвлөлдөж, 2 сар тутам цахимаар уулздаг шинэ практикийг эхлүүлсэн байна.

Ажлын алба 2 дугаар сард Дэд зөвлөлүүдтэй цахимаар уулзаж, Аймгуудын ОУИТБС-ын 2020 оны тайлан, 2021 оны төлөвлөгөө боловсруулж ирүүлэх талаар хэлэлцэж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Аймгийн засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний агуулгатай танилцуулж, харин ОУИТБС-ын талаар гэрээний тусгайлсан заалтуудад анхаарахыг хүсэлт болгосон байна.

Ажлын алба 4 дүгээр сард дахин уулзаж, Дэд зөвлөлийн холбогдох ажилтнуудад Ажлын төлөвлөгөө боловсруулах арга зүйг Иргэний нийгмийн байгууллагын мэргэжлийн хүмүүсээр заалгаж, уг хичээлийг хамтран зохион байгуулсан байна.

Ажлын алба 8 дугаар сарын 19, 27-нд Дэд зөвлөлүүдтэй цахимаар дахин уулзаж, 2021 оны эхний хагас жилд хийсэн ажлаа танилцуулж, ОУИТБС-ын бүсийн чуулганыг зохион байгуулах асуудлаар зөвлөлдөж, Улаанбаатар хот болон хэд хэдэн аймагт Ковид-19 цар тахлын нөхцөл байдал хүндэрч, өөрчлөгдсөн учир бүсийн чуулгадыг цахимаар зохион байгуулахаас өөр аргагүй болсныг харилцан санал солилцож, ойлголцсон байна.

Ажлын алба 5 дугаар сард “Орон нутгийн гэрээ”- ний асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд бүх 21 аймгийн Дэд зөвлөл, Засаг даргын тамгын газрын ажилтнууд оролцож, гэрээ байгуулах асуудлаар зөвлөгөө авахын хамт гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийн мониторинг хэрхэн явуулах талаар чиглэл авсан байна. Хэлэлцүүлэгт 90 гаруй албан тушаалтан оролцож, хэлэлцүүлгийг “Фейсбук-ийн Лайв”- аар нийтэд дамжуулсан байна. Хэлэлцүүлгийн өмнө, хойно оролцогчдоос мэдлэгийн түвшинг асуумжаар судалсан ба үр дүнг цахим сайт болон “Фейсбук” дээр байршуулсан болно.

УУХҮЯ, Ажлын албанаас 5 дугаар сард ОУИТБС-ын Төвийн бүсийн 4 дүгээр чуулганыг зохион байгуулж, чуулганд төвийн бүсийн 8 аймаг оролцсон бөгөөд Ковид-19 өвчний цар тахлын улмаас анх удаагаа цахимаар амжилттай зохион байгуулж, дараах асуудлуудтай танилцан хэлэлцсэн байна. Үүнд:

- УУХҮЯ-наас Ашигт малтмал тухай, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг танилцуулсан байна.
- Ашигт малтмал газрын тосны газраас ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хуваарилах шинэ журмыг танилцуулсан байна.
- Сангийн яамнаас Орон нутгийн хөгжлийн сангийн талаар танилцуулж, ажил хэрэгч хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна.

УУХҮЯ, Ажлын албанаас 10 дугаар сард ОУИТБС-ын Баруун бүсийн 3 дугаар чуулганыг зохион байгуулж, чуулганд баруун бүсийн 6 аймаг оролцсон бөгөөд Ковид-19 өвчний цар тахлын улмаас цахимаар зохион байгуулж, дараах асуудлуудтай танилцан хэлэлцсэн байна. Үүнд:

- УУХҮЯ-наас Ашигт малтмал тухай, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг танилцуулсан байна.
- Ашигт малтмал газрын тосны газраас ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хуваарилах шинэ журмыг танилцуулсан байна.
- Ажлын албанаас анх удаагаа ОУИТБС-ын мэдлэгийг сорих “АХА” тэмцээнийг чуулганы үеэр зохион байгуулж, түүнд компанийн төлөөлөл түрүүлсэн байна.

УУХҮЯ, Ажлын албанаас 12 дугаар сард ОУИТБС-ын Зүүн бүсийн 3 дугаар чуулганыг зохион байгуулж, чуулганд зүүн бүсийн 3 аймаг оролцсон бөгөөд Ковид-19 өвчний цар тахлын улмаас цахимаар зохион байгуулж, дараах асуудлуудтай танилцан хэлэлцсэн байна. Үүнд:

- УУХҮЯ-наас Ашигт малтмал тухай, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг танилцуулсан байна.
- Ашигт малтмал газрын тосны газраас ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хуваарилах шинэ журмыг танилцуулсан байна.
- Ажлын албанаас анх удаагаа ОУИТБС-ын мэдлэгийг сорих АХА тэмцээнийг чуулганы үеэр зохион байгуулж, түүнд орон нутгийн захиргааны төлөөлөл түрүүлсэн байна.

Эдгээр бага хурлуудын оролцогчдоос ил тод байдал, аймаг орон нутагт хэрэгжүүлэхэд анхаарах, нөхцөл байдлыг засч сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудад зөвлөмж боловсруулан, талуудад хүргэх, хурлын өмнө хойно оролцогчдын мэдлэг, хүлээлтийн судалгааг асуумжаар хийж, гарсан үр дүнг цахим сан, “Фейсбук” зэрэг мэдээллийн сүлжээнүүдэд байршуулж, олон нийтэд мэдээлэл өгч ирсэн байна.

Сургалтын үйл ажиллагаа.

Энэ жилийн тухайд Монгол Улсад Ковид-19 өвчний цар тахлын улмаас сургалтын үйл ажиллагаа зогсонги байдалтай байсан.

Тиймээс Ажлын алба сургалтуудаа цахим хэлбэрээр зохион байгуулах болсон бөгөөд 2020 оны ОУИТБС-ын тайланг гаргахад нь компаниудад туслах, зөвлөгөө өгөх цахим сургалт 4-ийг “Гуугл Миит” програм дээр зохион байгуулсан. Компанийн оролцоо өмнөх жилээс илүү байсан байна.

Ажлын алба Олон улсын санхүүгийн корпорац, Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран сэтгүүлчдийн сургалтыг 8 дугаар сарын 30-нд зохион байгуулж, нээлттэй мэдээллийн арга зүйг хэрхэн ашиглах арга зүйтэй танилцахын хамт Улсын Их хуралд өргөн баригдаад, хэлэлцэгдэхээр бэлэн болсон “Нийтийн мэдээллийн тухай” хуулийн төслийн үзэл баримтлалын талаар мэдээлэл авсан байна. Уг хуулийн төслөөр төрийн байгууллага дээр хүлээн авсан 60 гаруй төрлийн мэдээллийг ил тод болгох бөгөөд түүний дотор эцсийн өмчлөгчийн мэдээлэл багтаж байна.

Олон улсын санхүүгийн корпорац, Нээлттэй нийгэм, Мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагаагаа өргөжүүлж байгаа тухай

Ажлын алба Олон санхүүгийн корпорац, Нээлттэй нийгэм форумтай хамтран мэдээлэл харилцааны үйл ажиллагааны томоохон хэлбэр болох бүсийн чуулгад, Дэд зөвлөлийн сургалт, “Хакатон”, сургагч багш бэлтгэх мөн системтэйгээр ил тод болгох зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээр үргэлжүүлэн хэлэлцсэн байна. Ялангуяа ОУСК-д 2021 онд хамтарч хэрэгжүүлэх ажлыг Ажлын албанаас санал болгосон байна. Хэд хэдэн удаа цахим уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна.

ОУИТБС-ын Ажлын хэсгээс Нээлттэй нийгэм форумаас боловсруулан, ашиглалтад оруулсан “Ил тод гэрээ”- ний цахим санг Ажлын албанд шилжүүлэхээр шийдвэрлэсний дагуу хүлээлгэн өгөх ажил явагдаж байна. Хүлээлгэн өгөх ажлыг саадгүй хэрэгжүүлэх, цаашид санг удирдах зорилгоор Ажлын албанаас журам боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар журмыг батлуулан мөрдөж байна. Ажлын албанаас аймгийн Засаг даргын тамгын газар, ОУИТБС-ын Дэд зөвлөлийн төлөөлөлд энэ журмыг танилцуулж, холбогдох сургалтыг зохион байгуулсан.

Ажлын алба УУХҮЯ, ОУСК, Нээлттэй нийгэм форум, Хил хязгааргүй алхам ТББ-тай хамтран “Ил тод аймаг” туршилтын төслийг говийн бүсийн 4 аймгийг хамруулан эхлүүлж, үнэлгээ болон танилцуулах хуудсыг хамт боловсруулж, эдгээр аймгуудын албан тушаалтнуудад танилцуулах сургалт хийж, тусалцаа дэмжлэг үзүүлсэн бөгөөд 2022 оны 1 дүгээр улиралд энэ төслийн эцсийн дүнг гаргаж танилцуулна.

Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын Бизнесийн зөвлөл, Транспаренси интернешнл, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацтай олборлох салбарын засаглалыг

сайжруулах асуудлаар хийж буй үйл ажиллагаагаа уялдуулах хэлэлцүүлэг зохион байгуулж, хамтран ажиллахаар тохирсон нэг зүйл нь олборлох салбарын оны шилдэг ил тод компани шалгаруулах явдал болох юм.

Ажлын албанаас олборлох салбарын шилдэг ил тод компанийг шалгаруулахад нүүрс олборлох орон нутгийн өмчийн “Таван толгой” хувьцаат компани тодорч, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын батламж, ОУИТБС-ын Ажлын албаны нэрэмжит цомоор сайшаагдсан байна.

УУХҮЯ-наас өгсөн зааварчилгааны дагуу Нээлтэй Засгийн түншлэлийн 2021-2023 оны Үндэсний жилийн төлөвлөгөөг боловсруулахад Ажлын албанаас оролцож, энэхүү төлөвлөгөөнд эцсийн өмчлөгчийн асуудлыг оруулсан байна.

ОУИТБС-ын Ажлын хэсгийн хуралдаан

УУХҮЯ-наас өгсөн зааварчилгааны дагуу Ажлын алба Ажлын хэсгийн 2021 оны анхны буюу 53 дугаар хуралдааныг 2021 оны 2 дугаар сарын 25-нд цахимаар зохион байгуулж, ОУИТБС-ын мэдээллийг ашиглан авилгын эрсдэлийг тодорхойлох туршилтын төслийг хэрэгжүүлэх ажлын дэд хэсгийг байгуулсан байна. Дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсны 6 нь ОУИТБС-ын Ажлын гишүүд байсан болно. Үүнд:

1. Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн зохицуулагч Н.Дорждарь
2. Авилгатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан Б.Ганхуяг
3. Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд
4. Нүүрс ассоциацийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэцэцэг,
5. Транспаренси Интернейшнл ТББ-ын тэргүүн Л. Төр-Од,
6. Ил тод байдал сан ТББ-ын тэргүүн Д. Цэрэнжав,
7. Тогтвортой хөгжлийн төлөөх “Хариуцлагатай уул уурхайн санаачлага” ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга Д. Сүхбаатар
8. Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон

Энэхүү Ажлын дэд хэсэг нь ОУИТБС-ын мэдээллийг ашиглан авилгын эрсдэлийг тодорхойлох багийн ажлын даалгавар, гарсан судалгаа, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хянаж, Ажлын хэсэгт танилцуулан батлуулсан байна.

Мөн 53 дугаар хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцсэн байна. Үүнд:

1. Дэд зөвлөлүүдэд 2021 оны Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зааварчилгаа болон зөвлөмж өгөх;
2. Монголын ОУИТБС-ын Дэд зөвлөлүүдийн 2021 оны үйл ажиллагааны мониторингийг хэрэгжүүлэхийг Ажлын албанд үүрэг болгох;
3. Ажлын хэсгийн дараагийн хуралдааныг 3 дугаар сарын 22-26-ны хооронд зохион байгуулах, Ил тод гэрээний цахим сангийн үйл ажиллагааны талаар сонсох, мэдээлэх авах, цаашид хэрхэх талаар шийдвэр гаргах.

Ажлын алба УУХҮЯ-наас өгсөн чиглэлийн дагуу Ажлын хэсгийн 54 дүгээр хуралдааныг 2021 оны 3 дугаар сарын 21-нд цахимаар зохион байгуулсан бөгөөд хуралдаанаас Ил тод гэрээний цахим санг ОУИТБС-ын Ажлын албанд шилжүүлэх нь зүйтэй гээд холбогдох журмыг боловсруулж батлуулах шийдвэр гарсан мөн ОУИТБС-ын Төвийн бүсийн чуулганыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, нөгөө талаас Үндэсний зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, хэрэгжиж буй төслүүдийн уялдааг хэлэлцэхийг санал болгосон байна.

Ажлын алба УУХҮЯ-наас зааварласны дагуу Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгийн 55 дугаар хуралдааныг 2021 оны 6 дугаар сарын 30-нд цахимаар зохион байгуулсан байна. Ажлын албанаас

энэ хуралдаанд 2021 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн ажлын тайлан, ОУИТБС-ын Төвийн бүсийн 4 дүгээр чуулганы үр дүн, зөвлөмжүүдийг танилцуулсан байна. Мөн албанаас ОУИТБС-ын тайлагналын маягтад оруулах нэмэлт өөрчлөлт, тухайлбал уул уурхайн компанийн ирэх 1-2 жилийн төлөвлөгөө, экспорттой холбоотой мэдээлэл, худалдан авалтын хэмжээ, хандивын зарцуулалтын мэдээлэл, олборлох салбарын эдийг засагт үзүүлэх нөлөөлөл, төсөөлөл, ажлын байрны мэдээллийг оруулахаар танилцуулсны дагуу дэд хэсэг байгуулж, нэмэлт ажил хийсний дагуу холбогдох байгууллагуудад танилцуулахаар шийдвэрлэсэн байна. ОУИТБС-ын мэдээллийг ашиглан авилгын эрсдэлийг тодорхойлох туршилтын төслийн явцтай мөн хуралдаан танилцаж дараагийн хуралдаанд эцэслэхээр шийдсэн байна.

УУХҮЯ-ны заавраар Ажлын алба ОУИТБС-ын Ажлын хэсгийн 56 дугаар хуралдааныг 9 дүгээр сарын 30-ны өдөр цахимаар зохион байгуулж, сүүлийн 5 жилд ОУИТБС-ын тайлангаа гаргаагүй компаниуд, төрийн байгууллагуудын тухай танилцуулсан байна.

Хуралдаанаар мөн ОУИТБС-ын мэдээллийг ашиглан авилгын эрсдэлийг тодорхойлох туршилтын төслийг хэрэгжүүлсэн ББЗХ-ийн зөвлөхүүдийн тайлан, дүгнэлт, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Лидер Визон групп ХХК, Хүний хөгжил сургалтын төвийн гэрээт ажлын явцтай танилцаж, холбогдох шийдвэрүүдийг гаргасан байна. ОУИТБС-ын мэдээллийг ашиглан авилгын эрсдэлийг тодорхойлох туршилтын төслийн хүрээнд боловсруулсан ажлын төлөвлөгөөг ОУИТБС-ын 2022 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэгтгэж, Үндэсний зөвлөлөөр батлуулахаар тогтсон байна.

Ажлын алба УУХҮЯ-наас өгсөн удирдамжийн дагуу Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгийн 57 дугаар хуралдааныг 2021 оны 11 дүгээр сарын 23-нд, үргэлжлүүлэн 25-ны өдөр цахимаар зохион байгуулсан байна.

Хуралдаанаар Монголын ОУИТБС-ын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2022 оны Ажлын төлөвлөгөөний төсөл, Грант Торнтон аудит ХХК-аас гэрээний дагуу боловсруулсан Монгол Улсын ОУИТБС-ын 2020 оны буюу 15 дугаар, уян хатан нэгтгэл тайлангийн төсөл болон бусад асуудлыг хэлэлцэж, зарчмын хувьд ОУИТБС-ын 2020 оны буюу 15 дугаар, уян хатан нэгтгэл тайлангийн төсөлд Ажлын хэсгийн гишүүдээс гаргасан санал зөвлөмжийг нэгтгэн Үндэсний зөвлөлд танилцуулахыг зөвшөөрөхийн хамт Грант Торнтон ХХК-тай байгуулсан 24 тоот гэрээт ажлын хөлсний 30 хувийг гэрээний 4 дүгээр заалтын дагуу холбогдох банкны дансанд шилжүүлж төлөх зөвшөөрлийг Ажлын албанд өгсөн, мөн Монголын ОУИТБС-ын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2022 оны Ажлын төлөвлөгөөний төсөл, ОУИТБС-ын дэд зөвлөлийн чадавхийг нэмэгдүүлэх хэрэгцээний суурь судалгаа, түүнд үндэслэсэн стратегийн төсөлд Ажлын хэсгийн гишүүдээс өгсөн санал зөвлөмжийг тусган Үндэсний зөвлөлд танилцуулж, батлуулахыг Ажлын албанд даалгасан байна.

ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдаан

Эцэст нь Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 20 дугаар хуралдааныг УУХҮЯ цахимаар зохион байгуулж, Монголын 2022 оны Ажлын төлөвлөгөөний төсөл, Грант Торнтон аудит ХХК-аас гэрээний дагуу боловсруулсан Монгол Улсын ОУИТБС-ын 2020 оны буюу 15 дугаар, уян хатан нэгтгэл тайлангийн төслийг баталж, Ашигт малтмалын тухай хуулийн 48,10-д заасан ОУИТБС-ын тайлангаа гаргаагүй компаниудын тухай хэлэлцсэн байна.

Баталгаажуулалтын бэлтгэл

Ажлын алба ОУИТБС-ын ОУНБГ-тай хамтран Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгийн Баталгаажуулалтын урьдчилсан хэлэлцүүлгийг 2021 оны 6 дугаар сард цахимаар зохион байгуулж, 2022 оны 1 дүгээр сарын 1-нд эхлэх Монгол Улсын ОУИТБС-ын Баталгаажуулалтад бэлтгэх ажлыг эхлүүлсэн байна. Мөн түүнтэй зэрэгцэн “Ил тод гэрээ”, “Авилгын эрсдэлийг тодорхойлох аргачлалын”

тухай вебинарыг Ажлын хэсгийн гишүүдэд зохион байгуулсны үр дүнд Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгийн гишүүд олон улсад хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар зохих мэдлэгтэй болсон байна. Дараа нь 10, 11 дүгээр сард Баталгаажуулалтын цуврал вебинарыг зохион байгуулан тэдгээрт Ажлын хэсгийн гишүүд, Грант Торнтон компанийн төлөөллийг оролцуулан Баталгаажуулалтын маягтыг бөглөх зааварчилгааг өгсөн байна.

Ажлын албанаас Монголын ОУИТБС-ын оролцогч талуудын оролцоо, үр дүн үр өгөөж, ил тодын маягтуудыг бөглөж, ОУИТБС-ын ОУНБГ-ын Баталгаажуулалтын хэсэгт Грант Торнтон ХХК, Монголын уул уурхайн үндэсний ассоциац, Төлсөн авснаа нийтэл эвслээс холбогдох маягтуудыг бөглүүлэн хамт хүргүүлсэн бөгөөд Баталгаажуулалтын хавтаст хэргийг нээж, Ажлын албаны цахим сан дээр байршуулж, олон нийтэд ил тод болгосон байна.

Ажлын алба ОУИТБС-ын ОУНБГ-тай хамтран 8 дугаар сарын эхээр Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгийн вебинарыг “Эцсийн өмчлөгч” – ийн асуудлаар зохион байгуулж, дэлхийн дахинаа энэ чиглэлээр Монгол Улсын хийж байгаа үйл ажиллагааг танилцуулж, шинэ мэдээлэл өгсөн байна.

Мөн Ажлын алба ОУИТБС-ын ОУНБГ-тай хамтран 8 дугаар сарын 26-нд Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгийн вебинарыг “Эцсийн өмчлөгч” – ийн асуудлаар өргөн бүрэлдэхүүнтэйгээр тухайлбал, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг төрийн багйууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулж, цаашдын үйл ажиллагаагаа уялдуулах талаар тохиролцсон байна.

Харилцааны бусад асуудлууд

Ажлын алба ОУИТБС-ын ОУНБГ, “Нээлттэй өмчлөл” олон улсын байгууллагатай хамтран Эцсийн өмчлөгчдийг ил болгох замаар “Олборлох үйлдвэрлэлийг нээлттэй болгох нь” хэмээх Дэлхийн төслийг эхлүүлж, холбогдох мэдээлэл түгээх ажлыг мэдээллийн сувгуудаар түгээж, танилцуулсан байна.

Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны өөрийн хариуцсан ажлын хэрэгжилтийг Ажлын алба цахимаар жил бүр тайлагнаж байна.

Харилцааны мэргэжилтэн ажиллуулж байгаа нь

Ажлын албаны харилцааны мэргэжилтэнээр Л.Байгал оны эхэнд ажиллаж, Монголын ОУИТБС-ын сургалт загвар, Оролцогч талуудын зураглал, Харилцааны стратег, сувгийн судалгааг хийж, дуусгасан байна.

Ажлын алба шинээр харилцааны мэргэжилтэнээр Цэлмэгийг сонгон шалгаруулж, ажилд нь оруулсан бөгөөд харилцааны стратегийг шинэчилж, ОУИТБС-ын Ажлын хэсэгт танилцуулна.

ОУИТБС-ын Ажлын албаны санхүү, худалдан авалтын тайлан

Улсын төсвийн 2020 оны санхүүжилтийн санхүүгийн тайланг гаргаж, шилэн дансны цахим хуудас дээр байршуулж, 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Үндэсний аудитын газарт хүргүүлсэн байна.

АХБ-аар санхүүжих үйл ажиллагааны зарцуулалтын 2021 төлөвлөгөөг батлуулсан байна.

Дэлхийн банкны шугамаар 2021- 2022 онд хэрэгжүүлэх төслийн тооцоог хийж, УУХҮЯ, СЯ-д хүргүүлсэн бөгөөд дараа нь шинэчлэгдэж 2022-2023 он болж өөрчлөгдсөн, түүний дагуу бэлтгэл ажлыг хангаж байна.

Улсын төсвийн 2020 оны худалдан авалтын тайланг гаргаж, 2021 оны 1 дүгээр улиралд УУХҮЯ-д хүргүүлсэн болно.

Ажлын алба албан хэрэгцээндээ зөөврийн 3 компьютерийг хуваарилсан хөрөнгөнд багтаан худалдан авч, өдөр тутмын үйл ажиллагаа явуулахад техникийн бололцоотой болсон байна.

Бүтээгдэхүүн 3- ын хэрэгжилтийн явц: 100 хувь

Гуравдугаар бүтээгдэхүүний хэрэгжилтийн гол онцлог:

ОУИТБС-ын ихэнх Дэд зөвлөлүүд 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэнд идэвхтэй оролцдог болсон байна. Ковид-19 өвчний цар тахлын хязгаарлалт байгаа хэдий ч компаниудыг цахим сургалтанд хамруулж, 3 Бүсийн чуулгадыг зохион байгуулсан бөгөөд Баталгаажуулалтад амжилттай бэлтгэж чадсан байна. Бусад хамтран ажиллагч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралдаануудыг төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгуулсан байна. Харилцааны шинэ мэргэжилтэн ажилдаа хурдан гаршиж, харилцааны үйл ажиллагааг нийгмийн сүлжээний чиглэлээр түлхүү идэвхжүүлж байна.

Үйл ажиллагааны үнэлгээ-2021 он

Бүтээгдэхүүний дугаар	Гарах бүтээгдэхүүн	Хэрэгжилтийн ахицын гол түвшин
I	ОУИТБС-ын стандартыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа сайжруулах;	<ul style="list-style-type: none"> • ОУИТБС-ын 2020 оны тайлангаа 1419 компани гаргасан нь харьцангуй өндөр бөгөөд Ажлын албанаас компаниудад арга зүйн туслалцаа үзүүлсэний үр дүн гэж үзнэ. • Монгол Улсын ОУИТБС-ын 2020 оны тайланг боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгарулалт, гэрээт ажлууд хугацаандаа амжилттай хэрэгсэн байна. • ОУИТБС-ын цахим тайлагналын системийг сайжруулах ажил гэрээний дагуу хэрэгжиж, сүлжээ нь хэрэглэгчид ээлтэй болсон байна. • Монголын ОУИТБС-ын цахим санг өөрчлөн шинэчилж, мэдээллийг баяжуулсан байна. • УУХҮЯ-ны цахим санг өөрчлөн шинэчилсэн байна. • Монгол Улсын ОУИТБС-ын 2020 оны буюу 15-р тайланг боловсруулж, хэвлэн нийлүүлсэн байна. • Дэд зөвлөлийн үйл ажиллагааы стратег, үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэсэн байна.
II	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулсан байх;	<ul style="list-style-type: none"> • Гадаад, дотоод хуулийн зөвлөхүүд ЭБИТБТХ-ийн хуучин, шинэ хувилбарыг нэгтгэн боловсруулсан байна. • Ил тод байдлын тухай хуулийн судалгааг хуулийн зөвлөхүүд бэлтгэсэн байна. • Дурдсан хуулийн эцсийн хувилбарыг бэлтгэж УУХҮЯ-д хүргүүлж, хэлэлцүүлэгт бэлтгэсэн байна.
III	Мэдээлэл түгээх ажлыг сайжруулах, олборлох салбарын талаарх мэдээллийг олон нийтэд түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	<ul style="list-style-type: none"> • Ихэнх Дэд зөвлөлүүд 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд идэвхтэй оролцосн байна. • Ковид-19 өвчний цар тахлын хязгаарлалт байгаа хэдий ч компаниуд цахим сургалтанд идэвхтэй хамрагдсан байна. • Дэмжигч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралдаануудыг төлөвлөгөөний дагуу цахимаар амжилттай зохион байгуулсан. • Баталгаажуулалтад амжилттай бэлтгэж, Монгол Улс ОУИТБС-ын Баталгаажуулалтад бэлэн болсон байна.
Төслийн явцын нийт дүн		85,5 хувь

Ирэх 2022 оны Үйл ажиллагааны гол чиглэл

Ирэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гол чиглэл анхаарал бол Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг батлуулах, Ажлын албаны үйл ажиллагааг Улсын төсвөөр санхүүжүүлдэг болоход бэлтгэхэд оршиж байна.

Хоёрдугаар чиглэл бол ОҮИТБС-ын Баталгаажуулалтыг амжилттай хэрэгжүүлэх, ОҮИТБС-ын стандартыг хангаж байгаа зэрэглэлээ хадгалах явдал юм.

Гуравдугаар чиглэл бол харилцаа холбоо, ОҮИТБС-ын өгөгдлийн ашиглалтыг сайжруулах, Дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар арга хэмжээ авна.

---o-o-O-o-o---